



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 27

Төрийн ордон. Улаанбаатар хот

Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь :

1.Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсугай.

2.Тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр ашиглаж байгаа Эрдэнэтийн зэс-молибдений орд, Монгол Улсын Засгийн газраас бусад хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа Төмөртэйн овооны цайрын орд, Нарийн сухайтын нүүрсний орд, Бороогийн алтны үндсэн ордын одоогийн ашиглаж байгаа нөхцөлийг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсүгэй.

3.Тогтоолын хоёрдугаар хавсралтад заасан ашигт малтмалын ордын болон энэ тогтоол батлагдсанаас хойш нөөц нь илэрсэн ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлж байхыг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

4.Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой, Таван толгой, Цагаан суварга, Асгатын ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнийг хэрхэн эзэмших талаархи саналыг эхний ээлжинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

| Д/д | Ордын нэр | Ашигт малтмалын төрөл | Байршил | Тайлбар |
|-----|----------------|-----------------------|-----------------------|--|
| 1. | Таван толгой | Чулуун нүүрс | Өмнөговь, Цогтцэций | Тавантолгой ХК, Энержиресорс ХХК, Дайцуки ХХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна. |
| 2. | Нарийн сухайт | Нүүрс | Өмнөговь, Гурвантэс | Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан. |
| 3. | Багануур | Хүрэн нүүрс | Улаанбаатар, Багануур | Нөөц тооцсон талбайг хамааруулна. "Багануур" ХК олборлодог. |
| 4. | Шивээ Овоо | Хүрэн нүүрс | Говьсүмбэр, Шивээговь | Нөөц тооцсон талбайг хамааруулна. "Шивээ Овоо" ХК олборлодог. |
| 5. | Мардай | Уран | Дорнод, Дашбалбар | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна. |
| 6. | Дорнод | Уран | Дорнод, Дашбалбар | |
| 7. | Гурван булаг | Уран | Дорнод, Дашбалбар | |
| 8. | Төмөртэй | Төмрийн хүдэр | Сэлэнгэ, Хүдэр | Уг ордын тусгай зөвшөөрлийг "БЛТ" ХХК эзэмшиж байсныг 2006 онд цуцалсан. Нөөц тооцсон талбайг хамааруулна. |
| 9. | Оюу толгой | Зэс, молибдени | Өмнөговь, Ханбогд | Ордын нөөцийн тооцоо бүхий тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэхэд бэлтгэж байна. Бүлэг ордын хэмжээгээр ойлгоно. |
| 10. | Цагаан суварга | Зэс, молибдени | Дорноговь, Мандах | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна. |
| 11. | Эрдэнэт | Зэс, молибдени | Орхон, Баян-Өндөр | Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулагдаж байгаа. |
| 12. | Бүрэнхаан | Фосфорит | Хөвсгөл, Алаг-Эрдэнэ | Хөвсгөлийн их дархан цаазат газрын гадна ногдох нөөц тооцогдсон хэсэгт дөрвөн компани хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. |
| 13. | Бороо | Алт | Сэлэнгэ, | Монгол Улсын Засгийн |

| | | | | |
|-----|----------------|-------------------|------------------------|---|
| | | | Баянгол | газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан. |
| 14. | Төмөртэйн овоо | Цайр, хар тугалга | Сүхбаатар, Сүхбаатар | Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан. |
| 15. | Асгат | Мөнгө | Баян-Өлгий, Ногооннуур | Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ бүхий хамтарсан Монголросцветмет нэгдэл тусгай зөвшөөрлийг нь эзэмшиж байгаа. |

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

| д/д | Ордын нэр | Ашигт малтмалын төрөл | Байршил | Тайлбар |
|-----|----------------|-----------------------|--------------------------|---|
| 1. | Улаан-Овоо | Нүүрс | Сэлэнгэ, Түшиг | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |
| 2. | Өвдөг худаг | Нүүрс | Дундговь, Баянжаргалан | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо ашиглаж байгаа. |
| 3. | Баянтээг | Нүүрс | Өвөрхангай, Нарийнтээл | Хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 4. | Нүүрст хотгор | Нүүрс | Увс, Бөхмөрөн | Хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 5. | Хар тарвагатай | Нүүрс | Увс, Өмнөговь | Хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 6. | Адуунчулуун | Нүүрс | Дорнод, Хэрлэн | Хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 7. | Тэвшийн говь | Нүүрс | Дундговь, Сайнцагаан | Хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 8. | Талбулаг | Нүүрс | Сүхбаатар, Баруун-Урт | Хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 9. | Чандган тал | Нүүрс | Хэнтий, Мөрөн | Хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 10. | Хөөтийн хонхор | Нүүрс | Дундговь, Баянжаргалан | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |
| 11. | Хөөт | Нүүрс | Дорнод, Матад | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |
| 12. | Налайх | Нүүрс | Улаанбаатар, Налайх | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, уул техникийн нөхцөл хүндэрсэн. |
| 13. | Алаг тогоо | Нүүрс | Дорноговь, Даланжаргалан | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, нэмэлт хайгуулыг хувийн хөрөнгөөр хийсэн. |
| 14. | Зээгт | Нүүрс | Говь-Алтай, Чандмань | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 15. | Могойн гол | Нүүрс | Хөвсгөл, Цэцэрлэг | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 16. | Сайхан-Овоо | Нүүрс | Булган, Сайхан | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо хувьцаат компани ашиглаж байгаа. |
| 17. | Баргилт | Төмрийн | Хэнтий, Дархан | Улсын эрдэс баялгийн |

| | | | | |
|-----|---------------------------------|--------------------------------|------------------------------|--|
| | | хүдэр | | нөөцөд бүртгэгдээгүй. |
| 18. | Төгрөг нуур | Нүүрс | Төв, Баян | Улсын эрдэс баялгийн нөөцөд бүртгэгдээгүй. |
| 19. | Наран толгой | Алт | Төв, Жаргалант | Одоо бага хүчин чадлаар ашиглаж байгаа. |
| 20. | Тавт | Алт | Булган, Тэшиг | Хувийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц өссөн. |
| 21. | Төмөр толгой | Төмрийн хүдэр | Дархан-Уул, Хонгор | Тусгай зөвшөөрлийг цуцалсан. |
| 22. | Баян давааны бүлэг орд | Цагаан тугалга, гянтболд | Төв, Эрдэнэ | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор ашиглаагүй. |
| 23. | Улаан Уул | Цагаан тугалга, гянтболд | Баян-Өлгий, Улаанхус | Одоо бага хэмжээгээр ашиглаж байгаа. |
| 24. | Жанчивлан- гийн бүлэг орд | Цагаан тугалга, гянтболд | Төв, Эрдэнэ | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор ашиглаагүй. |
| 25. | Цагаан даваа | Цагаан тугалга, гянтболд | Төв, Баянчандмань | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор бага хэмжээгээр ашиглаж байгаа. |
| 26. | Мөнгөн Өндөр | Мөнгө | Хэнтий, Өмнөдэлгэр | Улсын эрдэс баялгийн нөөцөд бүртгэгдээгүй. |
| 27. | Хөх адар | Зэс, цайр | Баян-Өлгий, Толбо | Хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийгдэж байгаа. |
| 28. | Шаврын царам | Пироп | Архангай, Тариат | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор бага хэмжээгээр ашиглаж байгаа. |
| 29. | Шүдэн уул | Чулуун давс | Увс, Давст | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор ашиглаагүй. |
| 30. | Ширээ уул | Гөлтгөнө | Дундговь, Дэлгэрхангай | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |
| 31. | Өвдөг худаг | Хүрэн нүүрс | Дундговь, Өндөршил | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо ашиглаж байгаа. |
| 32. | Цайдам нуур | Хүрэн нүүрс | Төв, Баян | Нөөцийн зэрэг С2-оос доош үнэлэгдсэн. |
| 33. | Цагаан цав | Цеолит | Дорноговь, Сайхандулаан | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо бага хэмжээгээр ашиглаж байгаа. |
| 34. | Манхан уул | Фосфорит | Хөвсгөл, Алаг- Эрдэнэ | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |
| 35. | Онгилог нуур | Фосфорит | Хөвсгөл, Алаг- Эрдэнэ | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |
| 36. | Лугийн гол | Газрын ховор элемент | Дорноговь, Хатанбулаг | Нөөцийн зэрэг С2-оос доош үнэлэгдсэн. |
| 37. | Хонгор | Жонш | Дорноговь, Даланжаргалан, | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |

| | | | Айраг | |
|-----|-------|-------------------|-------------------|---|
| 38. | Улаан | Цайр, хар тугалга | Дорнод, Дашбалбар | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |
| 39. | Цав | Цайр, хар тугалга | Дорнод, Чойбалсан | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн. |